



**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,  
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг.  
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр.  
Утас: 26-35-06, Факс: (976-11) 31-81-69,  
<http://www.mnhi.gov.mn>

2021. 07. 09 № 03 / 1804  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г САНГИЙН ЯАМАНД Г

Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын болон харьяа төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн 2021 оны эхний хагас жилийн худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн боловсруулж, хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 43 хуудастай.

ТӨРИЙН НАРИИН БИЯГИЙН  
ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛ



d:\уухуя 2021 яам a5 docx

00 08 1413

## **ЗАХИАЛАГЧИЙН 2021 ОНЫ БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАЛТЫН ТАЙЛАН**

**2021 оны эхний хагас жилд**

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд-Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын хэмжээнд /Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн алба/ 2021 онд нийт 31,249.6 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/95 дугаар тушаалаар шинэчлэн батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажиллаж байгаа хэдий ч улс орны хэмжээнд үүссэн цар тахлын нехцөл байдлаас шалтгаалан зарим тендерийн үйл ажиллагаа хойшлогдох, тодорхой хугацаагаар саатах зэрэг сөрөг нөлөөлөл гарч байна. Мөн Засгийн газрын 2021 оны 93 дугаар тогтоол гарч, төсөвт тодотгол хийгдсэнтэй холбоотойгоор зарим төрлийн худалдан авах ажиллагаа төлөвлөгөөнөөс хасагдсан. Тайлант хугацаанд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын хэмжээнд тендер шалгаруулалт амжилттай болж, гэрээ байгуулагдсан 6,072.2 сая төгрөгийн худалдан авалт бүртгэгдсэн.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК, “Зүүнбаян төмөр зам” ХХК, “Эрчис ойл” ТӨХХК-иудын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийг үндэслэн хянан баталж, хэрэгжилтийн явцад хяналт тавин ажиллаж байна.

### **1. УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь нь 2021 онд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын урсгал зардал, хөрөнгийн зардал, геологи хайгуул, судалгааны аргачлал хяналтын зардал, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх нийт 12 нэр төрлийн 30,060.41 сая төгрөгийн өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг зохион байгуулахаар төлөвлөж, зохион байгуулан ажиллаж байна. Үүнээс геологи хайгуул, судалгааны аргачлал хяналтын зардлаас санхүүжих 3 нэр төрлийн 356.27 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг Үндэсний геологийн албандаа эрх шилжүүлэн гүйцэтгүүлж байна.

Тендер шалгаруулалтын журмаар ангилан үзэхэд нээлттэй тендер шалгаруулалт 3, тендер шалгаруулалтын онцгой журам-харьцуулалтын аргаар 6, зөвлөхийн үйлчилгээний тендер шалгаруулалтаар 3 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авахаар төлөвлөсөн.

Төлөвлөгөөнд тусгагдсан 12 нэр төрлийн 30,060.41 сая төгрөгийн өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг зохион байгуулж ажиллахаас 2021 оны эхний хагас жилийн байдлаар бичиг хэрэг, тээвэр шатахуун, бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс худалдан авах болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний яам, агентлагийн үйлчилгээний чанар, хүртээмжид

хэрэглэгчийн үнэлгээ хийх, программ хангамжийн тусгай зөвшөөрөл худалдан авах тендерүүд зарлагдан, нийт 5,495.6 сая төгрөгийн гэрээ байгуулагдсан.

Геологи, хайгуул судалгааны ажлын 15 багц тендерийн зарыг 03 дугаар сарын 19-ний өдөр нийтлүүлсэн бөгөөд 1, 2, 3, 6 дугаар багцад 4 дүгээр сарын 12-ны өдөр, 4, 5, 7-11, 15 дугаар багцуудад 5 дугаар сарын 5-ны өдөр хураангуй жагсаалт үүсгэн, урилга хүргүүлснээс эхний 4 багц буюу 1, 2, 3, 6 дугаар багцад гэрээ байгуулагдсан. 12-14 дүгээр багцууттай холбоотойгоор Тагнуулын ерөнхий газраас албан бичиг ирүүлсэн тул цаашид тендер шалгаруулалтыг хэрхэн явуулах талаар Сангийн яаманд хандаж чиглэл аваад байна.

Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын 8 багц тендерийн зарыг 03 дугаар сарын 17-ны өдөр нийтлүүлсэн бөгөөд шаардлагад нийцсэн тендер ирээгүй. Мөн Засгийн газрын 93 дугаар тогтоол гарч, худалдан авах ажиллагаанд төсөвлөгдсөн хөрөнгийг бууруулсан тул дахин тодотгол хийж, үнийн дүн болон багцын тоог өөрчлөн дахин тендерийн зарыг нийтлүүлээд, санал хүлээн авч байна.

Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын 2020 оны буюу 15 дугаар нэгтгэл тайлан боловсруулах, цахим тайлангийн мэдээллийг сайжруулах, чадавх хэрэгцээг судлах зөвлөх үйлчилгээний 3 багц тендерийн зарыг 03 дугаар сарын 17-ны өдөр нийтэлсэн боловч шаардлагад нийцсэн санал ирээгүй. Дахин 04 дүгээр сарын 12-ны өдөр зарласан бөгөөд 5 дугаар сарын 14-ны өдөр хураангуй жагсаалтад багтсан оролцогчдод урилга хүргүүлж, техникийн саналыг хянан үзээд 6 дугаар сарын 30-ны өдөр санхүүгийн саналыг үнэлсэн. Үнэлгээний хорооны шийдвэрийг танилцуулахаар бэлтгэж байна.

Захиалагчийн 2021 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөний дагуу худалдан авалтыг зохион байгуулахдаа тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр явуулж, тендерийн урилгыг Засгийн газрын худалдан авах ажиллагааны веб сайт, өдөр тутмын сонинд нийтлэн, шилэн дансанд явц, үр дүнг тухай бүр нээлттэй оруулж, дараах чиг үүргийг мөрдлөг болгон ажилласан. Үүнд:

1. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийг мөрдлөг болгон ажиллах,
2. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх хэсэгт заасан босго үнээс өндөр төсөвт өртөгтэй аливаа худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар хуулийн дагуу зохион байгуулах,
3. Тендерийн баримт бичгийг боловсруулахдаа өрсөлдөөнийг хязгаарлахгүй, аль нэг аж ахуй эрхлэгчдэд давуу байдал олгохгүй байх, бодит шаардлагаас хэтрүүлэн өндөр эсхүл тухайн бараа, ажил, үйлчилгээний эцсийн үр дүн гүйцэтгэлд шууд хамаарахгүй шалгуур үзүүлэлтийг тавихгүй байх, тендерийн шалгуур үзүүлэлтийг чанар эцсийн үр дүнд үндэслэн боловсруулах,
4. Тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр шуурхай зохион байгуулан, тендерийн урилга үр дүнг Засгийн газрын худалдан авах ажиллагааны веб сайтад нийтлэх,

5. Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоол /Дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны жагсаалт/-ын хэрэгжилтийг хангаж ажиллах,
6. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол /Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай/-ын 1.4 дэх заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах,
7. Худалдан авах ажиллагааны тайланг батлагдсан журмын дагуу тайлагнаж байх зэрэг болно.

Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг цахимаар зохион байгуулахтай холбогдуулан урилгыг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн дагуу [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим хуудас болон өдөр тутмын хэвлэлд нийтэлж, тендерийн үр дүнг сар бүр Шилэн дансанд байршуулан олон нийтэд мэдээлэн ил тод байдлыг ханган ажиллаж байна. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны худалдан авах ажиллагааны тайланг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын хавсралт маягтуудын дагуу тайлагнаж хавсаргав.

## **2. АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР**

Ашигт малтмал, газрын тосны газар нь 2021 онд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын урсгал зардал, “Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэг”-ийн хөрөнгөөс санхүүжүүлэх нийт 15 нэр төрлийн 860.87 сая төгрөгийн өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд 2021 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын А/79, 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын А/95, 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын А/144 дүгээр тушаалуудаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлтийг оруулан батлуулж, нийт 13 нэр төрлийн 782.5 сая төгрөгийн өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг зохион байгуулан ажиллаж байна.

Тендер шалгаруулалтын журмаар ангилан үзэхэд нээлттэй тендер шалгаруулалт 1, зөвлөхийн бусад үйлчилгээ 2, харьцуулалтын аргаар 3, шууд худалдан авалтаар 7 бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар тусгасан.

Төлөвлөгөөнд тусгагдсан 13 нэр төрлийн 782.5 сая төгрөгийн өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээг зохион байгуулж ажиллахаас хоёрдугаар улирлын байдлаар гэрээ байгуулагдсан 2, тендерийг нээж үнэлгээ хийх шатанд 2, тендер зарлан тендерийн материал хүлээн авч байгаа 1, зарлах хугацаа болоогүй 1, шууд худалдан авалтаар 7, үнэлгээний хороо байгуулагдсан 6 арга хэмжээг тус тус хуулийн дагуу зохион байгуулан ажиллаж байна. Дээрх арга хэмжээг зохион байгуулахдаа өрсөлдөөнийг хязгаарласан, аль нэг аж ахуйн нэгжид давуу эрх олгоогүй бөгөөд тендертэй холбоотой маргаан, гомдол тендерт оролцсон аж ахуйн нэгжээс ирүүлээгүй болно.

Байгууллагын 2021 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөний дагуу худалдан авалтыг зохион байгуулахдаа тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулан, тендерийн урилгыг Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим систем, өдөр тутмын сонинд нийтлэх, шилэн

дансанд явц, үр дүнг тухай бүр нийтлэн дараах чиг үүргийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Үүнд:

1. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийг мөрдлөг болгон ажиллах,
2. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх хэсэгт заасан босго үнээс өндөр төсөвт өртөгтэй аливаа худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар хуулийн дагуу зохион байгуулах,
3. Тендерийн баримт бичгийг боловсруулахдаа өрсөлдөөнийг хязгаарласан, аль нэг аж ахуй эрхлэгчдэд давуу байдал олгохгүй байх, бодит шаардлагаас хэтрүүлэн өндөр эсхүл тухайн бараа, ажил, үйлчилгээний эцсийн үр дүн гүйцэтгэлд шууд хамаарахгүй шалгуур үзүүлэлтийг тавихгүй байх, тендерийн шалгуур үзүүлэлтийг чанар эцсийн үр дүнд үндэслэн боловсруулах,
4. Тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр шуурхай зохион байгуулан, тендерийн урилга үр дүнг Засгийн газрын худалдан авах ажиллагааны веб сайтад нийтлэх,
5. Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоол “Дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны жагсаалт”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах,
6. Худалдан авах ажиллагааны тайланг батлагдсан журмын дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлж байх зэрэг болно.

Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг цахимаар зохион байгуулахтай холбогдуулан урилгыг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн дагуу [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим хуудас болон өдөр тутмын хэвлэлд нийтэлж, тендерийн үр дүнг сар бүр Шилэн дансанд байршуулан олон нийтэд мэдээлэн ил тод байдлыг хангаж ажиллаж байна.

Ашигт малтмал, газрын тосны газрын худалдан авах ажиллагааны тайланг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-аар батлагдсан маягтын дагуу тайлагнаж хавсаргав.

### 3. ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБА

Үндэсний геологийн алба нь 2021 онд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын ургал зардал, улсын төсвийн хөрөнгөөс санхүүжүүлэх нийт 6 нэр төрлийн 106.7 сая төгрөгийн өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд 2021 оны 5 дугаар сарын 05-ний өдрийн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын А/95 дугаар тушаалаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан батлуулж, Уул уурхай хүнд үйлдвэрийн яамнаас эрх шилжиж ирсэн 3 тендер нэмэгдэж, нийт 9 нэр төрлийн 462.9 сая төгрөгийн өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг зохион байгуулахаар батлуулсан.

Улс оронд үүссэн (Ковид-19) цар тахалтай холбоотойгоор зарим нэр төрлийн худалдан авах ажиллагааны хугацааг хойшлуулах арга хэмжээг авч, төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулсан.

Тендер шалгаруулалтын журмаар ангилан үзэхэд нээлттэй тендер шалгаруулалт 4, зөвлөхийн бусад үйлчилгээ 1, харьцуулалтын аргаар 1, шууд худалдан авалтаар 3 бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар тусгасан.

1. Бичиг хэрэг –Шууд худалдан авалт
2. Бага үнэтэй түргэн элэгдэх ахйн эд зүйлс - Шууд худалдан авалт
3. Шатахуун- Шууд худалдан авалт
4. Хамгаалтын сертификатын сунгалтын тендер- Нээлттэй тендер шалгаруулалт
5. Харуул хамгаалалтын хөлс- Нээлттэй тендер шалгаруулалт
6. Геологийн судалгааны багаж хэрэгсэл тендер- Нээлттэй тендер шалгаруулалт
7. Геологийн судалгааны ажлын арга аргачлал, заавар, норм, схем, программ хангамж боловсруулах тендер – Зөвлөх үйлчилгээ
8. Геологийн судалгааны ажлын арга аргачлал, заавар, норм хэвлүүлэх тендер - Нээлттэй тендер шалгаруулалт
9. Даатгалын үйлчилгээ – Харьцуулалтын арга

Төлөвлөгөөнд тусгагдсан 9 нэр төрлийн 462.9 сая төгрөгийн өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллахаас эхний хагас жилийн байдлаар гэрээ байгуулагдсан 1, шууд худалдан авалтаар 4, үнэлгээний хороо байгуулагдсан 2 арга хэмжээ байна. Эдгээр худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа өрсөлдөөнийг хязгаарлах, аль нэг аж ахуйн нэгжид давуу эрх олгоогүй бөгөөд тендер шалгаруулалттай холбоотой маргаан, гомдол тендерт оролцсон аж ахуй нэгжүүдээс ирүүлээгүй болно.

Байгууллагын 2021 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөний дагуу худалдан авалтыг зохион байгуулахдаа тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулан, тендерийн урилгыг Засгийн газрын худалдан авах ажиллагааны веб сайт, өдөр тутмын сонинд нийтлэх, шилэн дансанд явц, үр дүнг тухай бүр нийтлэн дараах чиг үүргийг мөрдлөг болгон ажиллав.

Үүнд:

1. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийг мөрдлөг болгон ажиллах,
2. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх хэсэгт заасан босго үнээс өндөр төсөвт өртөгтэй аливаа худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар хуулийн дагуу зохион байгуулах,
3. Тендерийн баримт бичгийг боловсруулахдаа өрсөлдөөнийг хязгаарласан, аль нэг аж ахуй эрхлэгчдэд давуу байдал олгохгүй байх, бодит шаардлагаас хэтрүүлэн өндөр эсхүл тухайн бараа, ажил, үйлчилгээний эцсийн үр дүн гүйцэтгэлд шууд хамаарахгүй шалгуур үзүүлэлтийг тавихгүй байх, тендерийн шалгуур үзүүлэлтийг чанар эцсийн үр дүнд үндэслэн боловсруулах,

4. Тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр шуурхай зохион байгуулан, тендерийн урилга үр дүнг Засгийн газрын худалдан авах ажиллагааны веб сайтад нийтлэх,
5. Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоол “Дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны жагсаалт”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах,
6. Худалдан авах ажиллагааны тайланг батлагдсан журмын дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлж байх зэрэг болно.

Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг цахимаар зохион байгуулахтай холбогдуулан урилгыг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн дагуу [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим хуудас болон өдөр тутмын хэвлэлд нийтэлж, тендерийн үр дүнг сар бүр Шилэн дансанд байршуулан олон нийтэд мэдээлэн ил тод байдлыг ханган ажиллаж байна.

Үндэсний геологийн албаны худалдан авах ажиллагааны тайланг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-аар батлагдсан маягтын дагуу тайлагнаж хавсаргав.

#### **4. “ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК**

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 49 дүгээр тогтоолоор баталсан төсөвт өртөгт үндэслэн 910,107.2 сая төгрөгийн санхүүжилттэй, нийт 3,037,141.0 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөг бүхий 447 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/21 дүгээр тушаалын хавсралтаар батлуулсан.

Үүнээс 2021 оны эхний хагас жилийн байдлаар нийт 21 тендер шалгаруулалтаар 50,211.9 сая төгрөгийн худалдан авалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн зохион байгуулж ажилласан.

Батлагдсан төлөвлөгөөнд тусгалгүйгээр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээ байхгүй болно.

Хэрэгжээгүй худалдан авалт 2,982,450.3 сая төгрөг байна. Үүнд:

- Цанхийн зүүн уурхайн гэрээт олборлогчийг сонгох - 1,771,900.3 сая
- Цанхийн зүүн уурхайн өрөмдлөг, тэсэлгээ - 239,102.9 сая
- Уурхайд техник худалдан авах -54,447.5 сая
- Бортээгийн уурхайн олборлолт, тэсэлгээ, ачилт – 736,469.1 сая

Цанхийн зүүн уурхайн гэрээт олборлогчийг сонгох, Цанхийн зүүн уурхайн өрөмдлөг тэсэлгээ хийх гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтыг зарласан ба ШӨХТГ-аас тус тендер шалгаруулалтуудыг бүхэлд нь хүчингүйд тооцсон тухай шийдвэр ирүүлсэн тул тендер шалгаруулалт зогссон.

Дэлхий нийтээр короновируст цар тахал дэгдсэний улмаас Монгол улсад өндөржүүлсэн бэлэн байдалд Компанийн дотоод үйл ажиллагаатай холбоотойгоор зарим худалдан авалтуудыг сүүлийн хагас жилд зохион байгуулахаар төлөвлөсөн ба тендер шалгаруулалт нь үргэлжилж байгаа нийт 53 төсөл байна.

Бүх тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн хүчинтэй байх хугацаанд нь хийж, холбогдох хууль, журамд нийцүүлэн ажиллалаа.

Тайлант хугацаанд тендерт оролцогчоос ШӨХТГ болон Сангийн яаманд тендер шалгаруулалттай холбоотой гаргасан гомдол, саналыг эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн, тухай бурд нь ТБОНӨХБАҮХАтХ-ийн 54, 55-р зүйлийн холбогдох заалт болон бусад хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэж ажилласан.

Мөн дотоодын үйлдвэрлэлийг дэмжих тухай Монгол улсын Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж ажиллаж байна. 2021 оны эхний хагас жилийн байдлаар дотоодын үйлдвэрүүдээс нийт 1,336.9 сая төгрөгийн барааг худалдан авсан байна.

Худалдан авах ажиллагааг 100% цахим систем ашиглан зохион байгуулж ажилласан буюу нийт 21 удаагийн цахим тендер шалгаруулалт. Худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажиллах явцад 4 төслийн тендер шалгаруулалт амжилтгүй болсон тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлд зааснаар гэрээ шууд байгуулсан ба мөн хуулийн 34.3-т зааснаар гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэх болсон үндэслэлийг Сангийн яаманд хүргүүлсэн болно.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой бараа /хөдөлмөр аюулгүй байдлын хувцас, хэрэгсэл/, ажил /Бортээг, Цанхийн Зүүн уурхайн уулын ажил/, үйлчилгээ /оффисын түрээс, ашиглалт/-ыг тогтвортой үзүүлэх этгээдийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн сонгон шалгаруулж 3 /гурав/ жилийн хугацаагаар гэрээ байгуулан ажиллах тухай шийдвэрлэсэн.

Компанийн худалдан авах ажиллагааны 2021 оны эхний хагас жилийн тайланг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-аар батлагдсан маягтын дагуу тайлагнаж хавсаргав.

## 5. “МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨХХК

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн 2021 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 19 нэр төрлийн 7,094.1 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг тусгасан бөгөөд үүнээс 2021 оны эхний хагас жилийн байдлаар 5 тендерийг цахимаар зарлаж, Оффисийн хэрэглээний программ хангамжийн нэг жилийн лиценз нийлүүлэх тендерийг сонгон шалгаруулалт дуусч, Мобинет ХХК-д 31.6 сая төгрөгийн гэрээ байгуулах эрх олгоод байна. Засгийн газрын 43 дугаар тогтоол гарсантай холбоотойгоор тавилга, эд хогшил худалдан авах 2 тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны газраас хүчингүй болгосон. Компьютер, техник хэрэгсэл болон сервер компьютер худалдан авах тендерийг хуулийн хугацаанд нь багтаан нээсэн, үр дүн хараахан гараагүй байна. Бусад төрлийн худалдан авах ажиллагаа, тендер шалгаруулалт зарлагдаагүй байна. Мөн ковид-19 цар тахалтай холбоотойгоор зарим худалдан авах ажиллагаа хойшлогдсон байдалтай байна.

Тайлант хугацаанд зарлагдсан тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн хүчинтэй байх хугацаанд хийсэн. Тендер шалгаруулалттай холбоотой ямар нэг зөрчил дутагдал, гомдол маргаан гараагүй.

Дотоодын үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүний худалдан авалт хийгээгүй.

Нийт 5 тендерийг цахим систем ашиглан зарлаад байгаа бөгөөд 2 тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны газраас хүчингүй болгосон. Мөн 1 тендерийн үр

дүнг цахимаар нийтэлж, гэрээ байгуулах эрхийг олгоод байгаа бөгөөд 2 тендерийн үнэлгээ хийгдэж байна.

Компанийн худалдан авах ажиллагааны 2021 оны эхний хагас жилийн тайланг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-аар батлагдсан маягтын дагуу тайлагнаж хавсаргав.

## 6. “ЭРЧИС ОЙЛ” ХХК

“Эрчис ойл” ХХК-ийн 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 181.15 сая төгрөгийн 5 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авахаар тусгагдсан. Засгийн газрын 2021 оны 74 дүгээр тогтоол, УУХҮ-ийн сайдын 2021 оны 01/1309 дугаар чиглэл хүргүүлэх албан тоот, компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 1 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Улсын нөөц бүрдүүлэх АИ-92 төрлийн автобензиний худалдан авах ажиллагааг зохион байгуулах чиглэл ирүүлсэний дагуу 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн батлуулах хүсэлт илгээж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А/151 дүгээр тушаалаар нийт 4 нэр төрлийн 71,719.2 сая төгрөгийн худалдан авах ажиллагаа шинэчлэгдэн батлагдсан. Уг тушаалаар тавилга эд хогшил, автомашин худалдан авах 2 худалдан авалтыг хасаж, нөөцийн шатахуун худалдан авах 1 ажил нэмэгдсэн болно.

Тайлант хугацаанд 1 тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар зохион байгуулан, 19.3 сая төгрөгийн гэрээ байгуулагдсан.

Төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авалт хийгдээгүй.

Зарлагдсан тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн хүчинтэй байх хугацаанд хийсэн. Тендер шалгаруулалттай холбоотой ямар нэг зөрчил дутагдал, гомдол маргаан гараагүй.

Нийт 1 тендерийг цахим систем ашиглан, амжилттай зохион байгуулсан.

Компанийн худалдан авах ажиллагааны 2021 оны эхний хагас жилийн тайланг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-аар батлагдсан маягтын дагуу тайлагнаж хавсаргав.

## 7. “ЗҮҮНБАЯН ТӨМӨР ЗАМ” ХХК

“Зүүнбаян төмөр зам” ХХК нь Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор баталсан төсөвт үндэслэн 1,250.98 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг боловсруулж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/31 дүгээр тушаалаар батлуулсан. Үүнээс эхний хагас жилийн байдлаар 627.2 сая төгрөгийн худалдан авалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн зохион байгуулж ажилласан байна.

Тухайн жилийн худалдан авах төлөвлөгөөнд тусгалгүйгээр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээ байхгүй.

Хэрэгжээгүй 623.75 сая төгрөгийн худалдан авалт байна. Үүнд:

- Тээврийн хэрэгсэл худалдан авах 60.0 сая
- Хэвлэл мэдээлэл, арга хэмжээ 104.0 сая
- Автомашин түрээс 117.5 сая
- Хурлын өрөөний тоног төхөөрөмж, хяналтын камер 30.25 сая
- Эрүүл мэндийн үзлэг, оношилгоо 21.6 сая
- ISO стандарт нэвтрүүлэх 18.0 сая
- Зөвлөх үйлчилгээ 113.4 сая
- Мэргэшүүлэх, мэдлэг олгох сургалт 32.0 сая
- Стандартын сургалт 17.5 сая

Компанийн дотоод үйл ажиллагаатай холбоотойгоор дээрх худалдан авалтуудыг сүүлийн хагас жилд зохион байгуулахаар төлөвлөсөн.

Тендер шалгаруулалт нь үргэлжилж байгаа нийт 1 худалдан авалт байна.

Тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн хүчинтэй байх хугацаанд нь холбогдох хууль, журамд нийцүүлэн хийж ажилласан.

Тайлант хугацаанд зарлагдсан тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн хүчинтэй байх хугацаанд хийсэн. Тендер шалгаруулалттай холбоотой ямар нэг зөрчил дутагдал, гомдол маргаан гараагүй.

Манай компани худалдан авалтын төлөвлөгөөний хүрээнд дотоодын үйлвэрээс худалдан авах чанар сандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт"-д багтсан бараа бүтээгдэхүүнийг худалдан авч, дотоодын үйлдвэрийг дэмжих тухай Монгол улсын Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэн ажилласан.

Худалдан авах ажиллагааны цахим системээр зарласан тендер шалгаруулалтын тоо нийт тендер шалгаруулалтын 100 хувь буюу 8 байна.

Гэрээний хэрэгжилтэд захиалга гаргасан нэгжийн төлөөллийг оролцуулан хяналт тавьж, гэрээ дуусгавар болмогц гэрээ дүгнэсэн акт үйлдэж, талуудаар гарын үсэг зуруулж баталгаажуулан ажиллаа.

Компанийн худалдан авах ажиллагааны 2021 оны эхний хагас жилийн тайланг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-аар батлагдсан маягтын дагуу тайлагнаж хавсаргав.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

2021.07.07.

## ЗАХИАЛАГЧИЙН 2021 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ /2021 оны эхний хагас жилд/

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөвт өртөг /сая.төгрөг/	Эрх шилжүүлэх эсэх /ТЕЗ-ийн нэр/	Гэрээний дүн /сая төгрөг/	Худалдан авах ажиллагаанд мөрдсөн журам	Худалдан авах ажиллагаанд мөрдсөн хугацаа							Уламжлалт/цахимаа р зарласан эсэх/	Тайлбар тодруулга
						Үндэслэлийн хороо байгуулах отноо	tender.gov.mn сайтад тендериийн урилга нийтэлсэн отноо	Сонин хэвлэлд тендериийн урилга нийтэлсэн отноо	Гэрээ байгуулах эрх олгосон отноо	tender.gov.mn-д нийтэлсэн отноо	Гэрээ дуусгаж дүгнэсэн отноо			
1	2	3	4	5	7	8	9	10	11	12	13	14	15	
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам														
Ургал зардал														
Хангамж, бараа материалын зардал														
1.1	Бичиг хэрэг/4 багц/	28.40	ҮҮХҮЯ	30.02	ХА	2020.12.15	2021.01.20	2021.01.20	2021.02.04	2021.03.25		цахим	Гэрээ байгуулгасан.	
	Багц-1. Бичгийн цаас	9.25	ҮҮХҮЯ	9.24	ХА	2020.12.15	2021.01.20	2021.01.20	2021.02.04	2021.03.25		цахим	Бичгийн цаас нийлүүлэх тендерт оролцогч "ТӨГС ДАРДАС" ХХК-иас ирүүлсэн тендерийн баримт бичгийн бурдэл болон үнийн саналд үнэлгээ хийж захиалагчийн шаардлагад нийцсэн тул тус компанийн сонгон шалгаруулж гэрээ байгуулах эрх нь 2021.02.11-ний өдөр нээгдэж гэрээ байгуулсан.	
	Багц-2. Бичгийн хэргийн материал	5.50	ҮҮХҮЯ	5.20	ХА	2020.12.15	2021.01.20	2021.01.20	2021.02.04	2021.03.25		цахим	Бичиг хэргийн материал нийлүүлэх тендерт оролцогч "ЗӨВӨНГӨ" ХХК-иас ирүүлсэн тендерийн баримт бичгийн бурдэл болон үнийн саналд үнэлгээ хийж захиалагчийн шаардлагад нийцсэн тул тус компанийн сонгон шалгаруулж гэрээ байгуулах эрх 2021.02.11-ний өдөр нээгдэж гэрээ байгуулсан.	
	Багц-3. Принтерийн хор	6.38	ҮҮХҮЯ	6.38	ХА	2020.12.15	2021.01.20	2021.01.20	2021.02.04	2021.03.25		цахим	Принтерийн хор нийлүүлэх тендерт оролцогч "ТӨГС ДАРДАС" ХХК-иас ирүүлсэн тендерийн баримт бичгийн бурдэл болон үнийн саналд үнэлгээ хийж захиалагчийн шаардлагад нийцсэн тул тус компанийн сонгон шалгаруулж гэрээ байгуулах эрх 2021.02.11-ний өдөр нээгдэж, гэрээ байгуулсан.	
	Багц-4. Хэвлэлийн материал	7.27	ҮҮХҮЯ	9.20	ХА	2020.12.15	2021.01.20	2021.01.20	2021.02.04	2021.03.25		цахим	Тус тендерт үнийн санал ирээгүй тул Засгийн газрын хэрг эрхлэх газраас 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн ХЭГ/175 дугаар албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу Яам, Засгийн Газрын Агентлаг, Аймаг, Нийслэлийн засаг даргын тамын газрууд төрөл бүрийн бланк, дугтуй, ном, сэтгүүл, урилга, танилцуулга, нэрийн хуудас, нийлгэг материалын ажлын болон мэргэжлийн үнэмлэхийн хавтас зэрэг бүтээгдэхүүнийг Засгийн газрын Хэвлэх үйлдвэрээр хэвлүүлнэ гэсэн байдаг юм байна. Тус албан бичгийг үндэсэл болгон Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨҮГ-тэй шүүд гарээ байгуулахаар шийдвэрлэн гэрээ байгуулсан.	

1.2	Тээвэр, шатахуун	17.92	ҮҮХҮЯ	17.92	ХА	2020.12.15	2021.01.14	2021.01.14	2021.02.01	2021.02.23	цахим	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хянан, үнэлэхэд тус хуулийн 14-16 дугаар зүйл, тендерийн баримт бичиг болон техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан буюу хамгийн сайн үнэлэгдсэн тендер гэж үзсэн тул Содмонгол групптэй гэрээ байгуулсан.
1.3	Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс Эд хогшил, ургсал засварын зардал	25.64	ҮҮХҮЯ	7.96	ХА	2021.01.06						Тухай бүр шууд худалдан авалтыг хийж байна.
1.4	Багаж, техник, хэрэгсэл Геологийн байгууллага	49.50	ҮҮХҮЯ	0.00	ХА	2021.01.06						Худалдан авалт хийгдээгүй
1.5	Геологи хайгуул, судалгааны ажил /15 багц/	29,178.33	ҮҮХҮЯ	5,363.86	НТШ	2021.03.15		2021.03.19			цахим	
	Багц-1. Бөөн хөх уул-50	1,021.78	ҮҮХҮЯ	890.19	НТШ	2021.03.15	2021.04.12	2021.03.19	2021.05.31	2021.06.14	цахим	Хамгийн бага санхүүгийн санал ирүүлсэн "Арвин майнинг" ХХК шалгарч гэрээ байгуулагдсан.
	Багц-2. Буйлст хүрэн уул-50	1,025.71	ҮҮХҮЯ	1,023.71	НТШ	2021.03.15	2021.04.12	2021.03.19	2021.05.31	2021.06.14	цахим	Хамгийн бага санхүүгийн санал ирүүлсэн "Минторес" ХХК шалгарч гэрээ байгуулагдсан.
	Багц-3. Ямаат уул-50	1,568.22	ҮҮХҮЯ	1,458.53	НТШ	2021.03.15	2021.04.12	2021.03.19	2021.05.31	2021.06.14	цахим	Хамгийн бага санхүүгийн санал ирүүлсэн "Литос майнинг" ХХК шалгарч гэрээ байгуулагдсан.
	Багц-4. Загал уул-50	1,162.61	ҮҮХҮЯ		НТШ	2021.03.15	2021.05.05	2021.03.19 2021.04.12	2021.06.28	2021.06.28	цахим	Гэрээ байгуулах эрх олгоод байна.
	Багц-5. Мезо-Кайнозой-2021	2,000.00	ҮҮХҮЯ		НТШ	2021.03.15	2021.05.05	2021.03.19 2021.04.12	2021.06.28	2021.06.28	цахим	Гэрээ байгуулах эрх олгоод байна.
	Багц-6. Гүний хагарал-1	2,000.00	ҮҮХҮЯ	1,991.43	НТШ	2021.03.15	2021.04.12	2021.03.19	2021.05.31	2021.06.14	цахим	Хамгийн бага санхүүгийн санал ирүүлсэн "Минторес" ХХК шалгарч гэрээ байгуулагдсан.
	Багц-7. Ховд геоэкологи-2021	800.00	ҮҮХҮЯ		НТШ	2021.03.15	2021.05.05	2021.03.19 2021.04.12			цахим	Төндөр оролцогчдын хураангуй жагсаалт үүсч, урилга хүргэгдсэн
	Багц-8. Гео-Орчин-2021	3,000.00	ҮҮХҮЯ		НТШ	2021.03.15	2021.05.05	2021.03.19 2021.04.12			цахим	Төндөр шалгаруулалтгыг 2 удаа зарласан боловч эрх бүхий оролцогч шалгараагүй
	Багц-9. ЭҮ-2-2021	5,500.00	ҮҮХҮЯ		НТШ	2021.03.15	2021.05.05	2021.03.19 2021.04.12	2021.06.28	2021.06.28	цахим	Гэрээ байгуулах эрх олгоод байна.
	Багц-10. ЭҮ-3-2021	5,500.00	ҮҮХҮЯ		НТШ	2021.03.15	2021.05.05	2021.03.19 2021.04.12	2021.06.28	2021.06.28	цахим	Гэрээ байгуулах эрх олгоод байна.
	Багц-11. ӨТТЭ-1-2021	1,000.00	ҮҮХҮЯ		НТШ	2021.03.15	2021.05.05	2021.03.19 2021.04.12	2021.06.28	2021.06.28	цахим	Гэрээ байгуулах эрх олгоод байна.
	Багц-12. Геологийн баримт-1	2,000.00	ҮҮХҮЯ		НТШ	2021.03.15		2021.03.19			цахим	
	Багц-13. Чулуун дээжийн сан-1	1,000.00	ҮҮХҮЯ		НТШ	2021.03.15		2021.03.19			цахим	Төндөр шалгаруулалттай холбоотойгоор Сангийн яамнаас чиглэл авсан.
	Багц-14. Цахим архив-1	1,000.00	ҮҮХҮЯ		НТШ	2021.03.15		2021.03.19			цахим	
	Багц-15 Төв ази 3D 5-р ўе шат	600.00	ҮҮХҮЯ		НТШ	2021.03.15	2021.05.05	2021.03.19 2021.04.12			цахим	Төндөр оролцогчдын хураангуй жагсаалт үүсч, урилга хүргэгдсэн
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ											
1.6	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил/7 багц/	221.63	ҮҮХҮЯ	0.00	Зөвлөх үйлчилгээ	2021.01.06					цахим	
	Багц-1. Монгол Улсын хар төмөрлөгийн нөөц, үйлдвэрлэл, технологи, зах зээлийн өнөөгийн байдал, хэтийн төлвийн судалгаа	24.75	ҮҮХҮЯ		Зөвлөх үйлчилгээ чанарын арга	2021.01.06		2021.03.17 2021.05.11 2021.06.02			цахим	2021.06.15-ны өдөр нээсэн. Сонгон шалгаруулалт хянан үзэх шатанд амжилтгүй болсон
	Багц-2. ҮҮХҮ-ийн салбарын хог хаягдлын нарийвчилсан судалгаа, шийдвэрлэх арга зам, аргачлал боловсруулах	24.75	ҮҮХҮЯ		Зөвлөх үйлчилгээ чанарын арга	2021.01.06	2021.05.15	2021.03.17			цахим	2021.06.15-ны өдөр нээсэн. Сонгон шалгаруулалт хянан үзэх шатанд амжилтгүй болсон

	Багц-3. Дотоодын түүхий эдээс өндөр чанарын металлургийн кокс үйлдвэрлэх технологи, коксын зах зээл, экспортын боломжийн судалгаа	24.75	УУХҮЯ		Зөвлөх үйлчилгээ чанарын арга	2021.01.06	2021.05.15	2021.03.17 2021.05.11 2021.06.02			цахим	Нийт 3 удаа зарласан боловч хуулийн 36.7-д заасны дагуу хураангуй жагсаалт үүсээгүй	
	Багц-4. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хуулийн шинэчлэлт, өөрчлөлттэй холбоотой тандан болон холбогдох бусад хуулийн төслийн судалгаа, боловсруулалтыг гүйцэтгэх		УУХҮЯ		Зөвлөх үйлчилгээ чанарын арга	2021.01.06		2021.03.17			цахим	Төсөвт тодотгол хийгдэж хасагдсан	
	Багц-5. "Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм"-ийн суурь судалгаа хийх, дүрмийн төсөл боловсруулах	24.75	УУХҮЯ		Зөвлөх үйлчилгээ чанарын арга	2021.01.06		2021.03.17 2021.05.11 2021.06.02			цахим	Нийт 3 удаа зарласан боловч хуулийн 36.7-д заасны дагуу хураангуй жагсаалт үүсээгүй	
	Багц-6. "Эрдэс баялагийн цахим засаглал" бүрдүүлэх хууль эрх зүйн орчны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, олон улсын сайн туршлагад сууринласан Үндэсний арга хэмжээ (хөтөлбөр)-ийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлагын тандан суурь судалгаа, арга хэмжээний төсөл боловсруулах эрдэм шинжилгээ, судалгаа	44.75	УУХҮЯ		Зөвлөх үйлчилгээ чанарын арга	2021.01.06		2021.03.17 2021.05.11 2021.06.02			цахим	Нийт 3 удаа зарласан боловч хуулийн 36.7-д заасны дагуу хураангуй жагсаалт үүсээгүй	
	Багц-7. "Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын санхүүгийн нэгтгэсэн тайлан /хөрөнгө оруулалт, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх геологи судалгааны ажлын санхүүгийн тайлан/ бэлтгэхдэх мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах	33.13	УУХҮЯ		Зөвлөх үйлчилгээ чанарын арга	2021.01.06		2021.03.17 2021.05.11 2021.06.02			цахим	Нийт 3 удаа зарласан боловч хуулийн 36.7-д заасны дагуу хураангуй жагсаалт үүсээгүй	
	Багц-8. Салбарын өртөг, үнэ, цэнийн гинжин сүлжээ, хамаарлын шинжилгээ хийх судалгаа, шинжилгээ	44.75	УУХҮЯ		Зөвлөх үйлчилгээ чанарын арга	2021.01.06		2021.03.17 2021.05.11 2021.06.02			цахим	Нийт 3 удаа зарласан боловч хуулийн 36.7-д заасны дагуу хураангуй жагсаалт үүсээгүй	
1.7	УУХҮС-ын эрхлэх асуудлын хүрээний яам агентлагийн үйлчилгээний чанар, хүртээмжид хэрэглэгчийн үнэлгээ хийх	12.00	УУХҮЯ	11.36	ХА	2021.02.04	2021.03.01	2021.03.01	2021.03.12	2021.06.14	2021.04.30	цахим	"Эс Ай Си Эй" ХХК шалгарч гэрээ байгуулагдсан.



Эд хогшил, урсгал засварын зардал												
1.5	Багаж техник хэрэгсэл	9.50	АМГТГ		Шууд худалдан авалт	2021.02.01						Хуульд заасан босго үнийг үндэслэн 6.98 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн.
1.6	Урсгал засвар үйлчилгээ	3.5	АМГТГ		Шууд худалдан авалт	2021.02.01						Сангийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 148 тоот тушаалаар батлагдсан 2021 оны төсвийн хуваарьт Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэжилтийн хүрээнд 2021 оны 03 дугаар сар, 04 дүгээр саруудад өөрчлөлт орсноор Урсгал засварын зардлын хуваарь 12 дугаар сард тавигдсан тул худалдан авалт хийгдээгүй болно.
	Дүн	13.02		0.00								
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ												
1.7	Харуул хамгаалалтын хөлс	44.4	АМГТГ	41.76	ХА	2021.02.01	2021.03.22	2021.03.22	2021.04.09	2021.04.30	Цахим	АМГТГ-ын даргын 2021 оны 2 дугаар 01-ний өдрийн А/17 тоот тушаалаар үнэлгээний хороо байгуулагдан ТББ-ийг боловсруулан 2021 оны 3 дугаар сарын 22-нд зарласан бөгөөд 4 дүгээр сарын 02-нд нээсэн. З компаний материалаа ирүүлсэн бөгөөд шаардлагад нийцсэн хамгийн бага үнийн санал ирүүлсэн "Бумбат зүрх" ХХК шалгарч гэрээ байгуулан, гэрээний дагуу Харуул хамгаалалтын ажлыг эхлүүлэн ажиллаж байна.
1.8	Даатгалын үйлчилгээ /2 багц/	29.7	АМГТГ		ХА	2021.05.11	2021.06.21	2021.06.21			Цахим	АМГТГ-ын даргын 2021 оны 5 дугаар 11-ний өдрийн А/70 тоот тушаалаар үнэлгээний хороо байгуулагдан ТББ-ийг боловсруулан 2021 оны 6 дугаар сарын 21-нд зарласан бөгөөд 7 дугаар сарын 02-нд нээн.
	Дүн	74.15		41.76								
	Нийт дүн Урсгал зардлаас	122.46		41.76								
2 Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэгийн хөрөнгө												
2.1	Геофизикийн чичирхийллийн судалгааны соронзон хальс уншигч тоног төхөөрөмж	350.00	АМГТГ	49.94	ХА	2021.05.11	2021.06.11	2021.06.11	2021.07.02		Цахим	АМГТГ-ын даргын 2021 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн А/68 тоот тушаалаар үнэлгээний хороо байгуулагдсан. Тендерийг тендер шалгаруулалтын онцгой журмаар 6 дугаар сарын 11-ний өдөр зарлаж, 6 дугаар сарын 24-ний өдөр нээсэн. Тендер 1 компаний материалаа ирүүлсэн бөгөөд тендерийг хянан үзэж, үнэлгээ хийн ТББ-т тавигдах шаардлага болон техникийн тодорхойлолтод нийцсэн тул ТБОНӨХБАҮХАТ хуулийн 27.3, 28.7.4 дэх заалтын дагуу шалгарч гэрээ байгуулах мэдэгдлийг 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдөр хүргүүлэхээр бэлтгэсэн.
2.2	Шатахуун октан тодорхойлогч УИТ-85M багажны оношилгоо, тохиргоо, засвар, үйлчилгээ	50.00	АМГТГ		ХА						Цахим	Засгийн газрын 43-р тогтоол, Ковид-19 цар тахлын улмаас өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбоотойгоор зарлах хугацааг хойшлуулсан.

2.3	Туулах чадвар сайтай 2 ширхэг автомашин худалдан авах	470.00	АМГТГ	445.80	НТШ	2021.01.20	2021.02.03	2021.02.03	2021.03.12	2021.03.19	Цахим	АМГТГ-ын даргин 2021 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн А/05 дугаар тушаалаар үнэлгээний хороо байгуулагдсан. Тендерийг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 2 дугаар сарын 03-ны өдөр зарлаж, 3 дугаар сарын 5-ны өдөр нээсэн. Тендерт 1 компани материалаа ирүүлсэн бөгөөд тендерийг хянан үзэж, үнэлгээ хийн ТББ-т тавигдах шаардлага болон техникийн тодорхойлолтод нийцсэн тул ТБОНХӨБАУХАТ хуулийн 27.3, 28.7.4 дэх заалтын дагуу шалгаруулж, гэрээ байгуулах мэдэгдлийг 2021 оны 3 дугаар сарын 12-ны өдөр Мөнххада ХХК-д хургуулсан. 3 дугаар сарын 23-ны өдөр 21/034 тоот гэрээг байгуулан 3 дугаар сарын 25-ны өдөр АМГТГ-ын даргин А43 дугаар тушаалаар байгуулагдсан автомашин хулээн авах комисс акт үйлдэн тус 2 автомашинийг хулээн авсан болно.
2.4	Компьютер, принтер болон бусад техник хэрэгсэл	70.00	АМГТГ		ХА	2021.05.11	2021.06.11	2021.06.11			Цахим	АМГТГ-ын даргин 2021 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн А/68 тоот тушаалаар үнэлгээний хороо байгуулагдсан. Тендерийг тендер шалгаруулалтын онцгой журмаар 6 дугаар сарын 11-ний өдөр зарлаж, 6 дугаар сарын 24-ний өдөр нээсэн. Уг тендерт нэг ч компани материалаа ирүүлээгүй бөгөөд амжилтгүй болсон тул 2021 оны 7 дугаар сарын 02-ны өдөр дахин зарлахаар төлөвлөсөн.
2.5	Химийн бодис ашиглах тусгай зөвшөөрөлтэй холбогдуулан байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийлгэх	20.00	АМГТГ		Шууд худалдан авалт						Цахим	Хуульд заасан босго үнийг үндэслэн ШХА-аар зохион байгуулахаар ажиллаж байна.
<b>Нийт дүн /ТГУАДХ-өөс/</b>		<b>960.00</b>		<b>495.74</b>								
<b>Нийт дүн</b>		<b>1,082.46</b>		<b>537.50</b>								
<b>Үндэсний геологийн алба</b>												
<b>Хангамж бараа материал</b>												
1.1	Бичиг хэрэг	14.0	ҮГА		Шууд худалдан авалт							Хуульд заасан босго үнийг үндэслэн шууд худалдан авалт хийсэн.
1.2	Бага үнэтэй түргэн злэгдэх ахуйн эд зүйлс	8.4	ҮГА		Шууд худалдан авалт							Хуульд заасан босго үнийг үндэслэн шууд худалдан авалт хийсэн.
1.3	Шатахуун	8.4	ҮГА		Шууд худалдан авалт							Хуульд заасан босго үнийг үндэслэн шууд худалдан авалт хийсэн.
<b>Дүн</b>		<b>30.8</b>		<b>0.0</b>								
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ</b>												
1.4	Харуул хамгаалалтын хөлс	30.0	ҮГА	28.0	НТШ	2021.01.13	2021.01.30	2021.01.30	2021.03.23	2021.01.30	цахим	Тендерт "Шүтээн уул" ХХК шалгарч, 2021/22 тоот гэрээ байгуулсан.
1.5	Серверийн хамгаалалтын сертификат сунгалт	34.4	ҮГА		НТШ	2021.05.18	2021.06.08	2021.06.08			цахим	

1.6	Даатгалын үйлчилгээ	11.5	ҮГА	11.1	Шууд худалдан авалт								Нийт 3 даатгалын компанийн санал авч хамгийн бага үнийн саналтай, 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдөр зарласан бөгөөд "Хаан даатгал" ХХК шалгарч Г-21307153 Г-21307153 тоот гарээг тус тус байгуулсан.
	Дүн	75.90		39.10									
	Нийт дүн	106.70		39.10									
	ҮҮХҮ-ийн сайдын багцын дүн	31,249.56		6,072.18									
<b>IV</b>													
<b>"Эрдэнэс Тавантолгой" ХК</b>													
1	Хотхоны гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгох	1,262.2	ЭТТ	1,158.2	НТШ	2020.11.03	2020.12.25	2020.12.25	2021.03.03	2021.03.16		цахим	"Билгүүн од констракшн" ХХК
